

ДУНДГОВЬ АЙМГИЙН ИТХ, ЗДТГ-ЫН 2019 ОНЫ 8 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Архивийн улсын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Серверийн өрөөнд агааржуулалтын системийг суурилуулж дууслаа. “Уяхан замбуу тивийн наран урлагын их наадам”-ыг зохион байгуулахтай холбогдуулан бэлтгэл ажлын талаар цахим хурлыг зохион байгуулж хуралд аймгийн болон 15 сумын урлагийн их наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүд оролцлоо.

2019.08.09-12-ны өдрүүдэд Зууны манлай уртын дууч Ж.Норовбанзадын нэрэмжит “Уяхан замбуу тивийн наран 3000 уртын дууч, морин хуурчид”-ын урлагийн их наадмыг Гурвансайхан сумын нутаг дах Их газрын чулууны уулны Задгай театрт амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Дундговь аймгийн 3200 гаруй уртын дууч, морин хуурчдын тоглолт, аймгийн ТХДЖТ, ТТХТ-ын уран бүтээлчдийн тоглолт, Дундговь аймгаас төрсөн урлаг, соёлын алдартан гавьяатнуудын тоглолт, яруу найргийн Уран үгсийн чуулган, үндэсний өв уламжлал, ёс заншлыг сурталчилсан Бэсрэг наадам, Монгол хүрээ зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдаж гадна дотно 10 гаруй мянган хүн ирж үзэж сонирхсон байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.16-д “Гадаад харилцааг бүх талаар хөгжүүлэх, аймаг орон нутгаа гадаадын улс орнуудад таниулах үйл ажиллагааг эрчимжүүлж, Ази, Европын зарим улс орнуудтай шинээр харилцаа холбоо тогтоон хамтран ажиллана” гэсэн зорилтын хүрээнд Япон Улсын Эхиме мужийн төлөөлөгч 16 хүнийг Бага газрын чулууны ууланд хүлээн авч уулзалт НцБүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой 2019 онд тохиож буйтай холбогдуулан Вьетнам улстай холбоо тогтоон харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх хүсэлтийг гадаад харилцааны яаманд хүргүүллээ.

11 сум, 12 байгууллагын төрийн захиргааны 270 албан тушаалын тодорхойлолтыг цахимаар албан тушаал бүрээр авч хянасан байна. Иргэдийн эрх зүйн мэдлэгт зохиулсан цахим гарын авлагуудыг аймгийн албан ёсны page хуудас болон цахим хуудсанд байршууллаа.

Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудасны англи болон гар утасны хувилбарыг нэмэлт шинэчлэлүүдийг хийж гүйцэтгэн холбогдох мэдээллүүдийн баяжилтыг хийлээ. Төрийн шагналаар шагнуулахаар ирүүлсэн 33 иргэний тодорхойлолтыг хянан холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлээ.

Нутгийн захиргааны байгууллагын “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах” арга зүйн сургалтад оролцож Аймаг сумын ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга, Засаг даргын томилдог 8 агентлагийн дарга, сумын ЗДТГ-ын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хэлэлцүүлэн батлахаар болоод байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Өглөг, авлага

№	Өглөг, авлага	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Үлдэгдэл
1	Өглөг	389,695,4	95,046,9	49,327,6	435,414,7
2	Авлага	496,739,1	10,584,1	26,246,9	481,076,4
Нийт		886,434,5	105,631,0	75,574,5	946,491,1

Төсвийн гүйцэтгэл

№	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	35,572,270,6	34,879,841,9	98,1%

Орлого

№	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	14,343,290,9	16,017,820,3	111,7%

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Захиргааны хэм хэмжээний актын 18 дугаарт Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Элс хайрганаас авах төлбөр, хураамж тогтоох тухай” 17 дугаар тогтоолыг улсын нэгдсэн санд бүртгэснийг нийтлэсэн байна. Нийтийн албанд нэр дэвшсэн 2 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, томилогдсон 2 албан тушаалтны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр хуулийн хугацаанд хүлээн авч, програмд баталгаажуулан бүртгэж Авлигатай тэмцэх газарт хүргүүллээ. Бүх нийтийн эрх зүйн боловсролын Үндэсний зөвлөлийн 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Эрх зүйн хөтчийн ажиллах журам, эрх зүйн хөтөчтэй байгуулах гэрээ, өдөр тутмын ажлын бүртгэл, ажил дүгнэх шалгуур үзүүлэлт” зэргийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, сум бүрт бэлтгэгдсэн эрх зүйн хөтөч нарт хүргүүллээ. Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Төрийн болон байгууллагын архивын хөгжил, төлөвшилт” улсын үзүүлэх сургууль-зөвлөгөөнд аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Эрдэнэсүрэн, ХЭЗХ-ийн дарга Б.Түвшинбаяр, төрийн архивын сан хөмрөгч Ч.Оюунсайхан, ЗДТГ-ын архивын ажилтан С.Батсайн нар оролцлоо. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт тус оноос эхлэн програмд орж байгаа тул эхний ээлжинд 2018 оны хэрэгжилтийг оруулах ажлыг хийж, аймгийн ЗДТГ-ын даргаар хянан баталгаажуулахад бэлэн болгов.

Гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл: Гэмт хэргийн шинжтэй 7 гомдол мэдээлэл бүртгэгдэж 3 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж, 1 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, хэрэг бүртгэлтийн 2 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 2 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж, иргэдэд учирсан 3 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлсэн. 10 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна. Зөрчлийн шинжтэй 17 гомдол бүртгэгдэж, Ердийн журмаар 232 иргэнийг 4.770.000 төгрөгөөр, хялбаршуулсан болон зөрчлийн хэрэг нээж 11 иргэнийг 2.355.000 төгрөгөөр торгож, 1 жолоочийн эрхийг хассан байна. Уяхан замбуу тивийн наран 3000 морин хуурч, уртын дуучдын урлагийн наадмын хамгаалалтанд 2019.08.08-2019.08.12-ны өдрүүдэд цагдаагийн газрын 86 алба хаагч ажиллаж ямар нэгэн гэмт хэрэг, зөрчилгүй ажилласан. “Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тасгийн алба хаагчид орон нутгийн хатуу хучилттай авто замд хяналт шалгалтыг хийж хурд хэтрүүлж зөрчил гаргаж байгаа жолооч нарт хуулийн дагуу арга хэмжээ авч зурагт хуудас 100 ширхэгийг тараан ажиллалаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН

ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс: Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын 2 дугаар ээлжийн бүртгэлийг 8 дугаар сарын 6-7-ний өдрүүдэд зохион байгуулахтай холбогдуулан ХХҮЕГазраас онлайн хурлыг хийж шалгалтын бүртгэлийн талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан. Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны

оноотой санал нийлэхгүй дахин судалгаанд хамрагдах хүсэлт ирүүлсэн Сайнцагаан сумын 34 өрхийн дахин судалгааг авч байна. Их газрын чулуунд болсон “Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадмын үйл ажиллагаанд байгууллага хамт олноороо оролцож, Бэсрэг наадам болон Айраг дэмбээний арга хэмжээг зохион байгуулсан. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж тусламж хөнгөлтийн 8 дугаар сарын санхүүжилтэд 280,4 сая төгрөгийг ХААН болон Төрийн банкуудаар олгож байна. МСҮТөвийн сургагч багш О.Цэнгэлмаатай хамтран байгууллагын нийт ажилтан албан хаагчдыг ХАБЭА-н сургалтанд хамруулж ХАБЭА мэдлэгийн олгон газрын дэргэдэх ахмадын амралтад эрсдлийн үнэлгээ хийж аюулыг арилгах төлөвлөгөө боловсруулан ажиллаа. Хулд, Луус сумдад газрын дотоод хяналтын баг удирдамжийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгож буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт болон нийгмийн халамжийн үйлчилгээний зарцуулалтад хяналт шалгалт хийж ажиллаа. ХХҮЕГазартай хамтран ажиллах гэрээ байгуулан ахмалдын амралт сувилалын үйлчилгээ үзүүлж буй 9 аж ахуйн нэгжид 4,6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Сайнцагаан, Баянжаргалан, Луус, Дэлгэрцогт сумдын малчдын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан 9 өрхөд 41 сая төгрөгийн 728 толгой мал, Адаацаг, Дэлгэрхангай, Гурвансайхан, Говь-угтаал сумдын малчдын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан 9 өрхөд 41 сая төгрөгийн 811 толгой мал тус тус олгоод байна. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүрээнд 6 сумын 7 дэлгүүрийн 18,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. 0-3 настай хүүхэд асарч буй эхчүүдийн цалинтай эхийн тэтгэмжийн 8 дугаар сарын санхүүжилтэд 2209 эхэд 109,3 сая төгрөгийг олгосон.

Эрүүл мэндийн газар: Жил бүр зохион байгуулдаг Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах уралдаанд 2018 онд нийт 4 байгууллага материал ирүүлсэнээс Цагдаагийн газар болзолыг хангаж Эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар шалгарч өргөмжлөл, хаяг, мөнгөн шагналыг гардуулан өглөө. Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх,эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд “Хоолны хордлого, суулгалт” сэдвээр үйлчлүүлэгч нарт Яаралтай түргэн тусламжийн тасгаас сургалт зохион байгууллаа. Нийт 70 үйлчлүүлэгч хамрагдаж урьдчилан сэргийлэх зөвлөмж гарын авлага 60 ширхэгийг тараалаа. Анхан ба хоёрдугаар шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төв ЖАЙКА Олон улсын байгууллага Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг хамтран Нэгдсэн эмнэлэг дээр “Зүрх зогссон үеийн яаралтай тусламж, Амилуулах суурь тусламж үзүүлэгч бэлтгэх, Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ лавшруулсан тусламж” зэрэг агуулгын хүрээнд сургалт зохион байгуулж Өмнөговь, Дундговь аймгийн Яаралтай тусламжийн эмч нар оролцлоо. 2019 оны 6 дугаар сард ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захирал Такеши Касай Дундговь аймагт хийсэн аичлалын хэлэлцээрийн дагуу Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын суурин төлөөлөгч Сергей Диордица, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга Я.Буянжаргал нар болон албаны бусад мэргэжилтнүүдийн хамт 2019 оны 8 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд тус аймагт ажиллах үеэр аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Нарантуяа нар “Аймгийн Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх” чиглэлээр санал бодлоо солилцож, цаашид хамтран ажиллахаар боллоо. “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын IV судалгаа”-г Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрдэм шинжилгээний судлаач нартай хамтран Цагаандэлгэр, Говь-угтаал, Сайнцагаан, Дэрэн сумдад авч байна. 2018 онд гепатит В вирусын эсрэг вакцинд хамрагдаагүй үлдсэн эрүүл мэндийн ажилтнууд болон 2019 онд шинээр ажилд орсон гепатит В вирусын халдваргүй ажилчдын тоог гаргаж Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлэв. Эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн үй ажиллагаа явуулах магадлан итгэмжлэл олгох комисс Дундговь аймгийн Сайнцагаан, Дэлгэрхангай, Луус, Дэлгэрцогт сумдын эрүүл мэндийн төв болон Өөшийн сувилалд тус тус ажиллаж байна. Эрүүл мэндийн яам, Монголын сумын эмч мэргэжилтний холбооны дэмжлэгтэйгээр Баянжаргалан, Гурвансайхан, Өлзийт, Хулд сумдын нутагт ашигт малтмалын уул уурхай эрхлэгч 13 аж ахуй

нэгжийн 280 гаруй ажиллагсдыг сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын идэвхитэй эрт илрүүлэг үзлэгт хамруулж байна. “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд тэмбүү өвчний тархалтыг бууруулах, улмаар устгах зорилгоор “Тэмбүүг устгая” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Эрүүл мэндийн яаманд хүргүүллээ. Эрүүл мэндийн газар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн албатай хамтран Нэгдсэн эмнэлэг, 14 сумын эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн засвар үйлчилгээ, тохируулга хийх шаардлагатай тоног төхөөрөмжүүдэд тохиргоо хийж, засвар үйлчилгээ хийлээ. “Тамхинаас гаргах зөвлөгөө өгөх арга зүй” сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэнүүдийг хамруулан зохион байгуулав.

Боловсрол, спорт, соёл урлагийн чиглэлээр: Музейн 70 жилийн ойд зориулан гаргах түүхийн номын эх бэлтгэлийн ажлыг хийж байна. Дундговь аймгийн харъяат Д.Лувсанбанзар ламын мэндэлсний 105 жилийн ойд зориулан гаргах үзэсгэлэнгийн бэлтгэл ажил хийгдэж байна. Хүүхдийн спортын 6-р их наадамд оролцох тамирчдын мэдээллийг <https://sportgames.mn> цахим программд шивж оруулаад байна. Хүүхдийн спортын 6-р их наадмын таеквондогийн төрөлд оролцох багийн тамирчид Моронато клуб, Сүхбаатар аймгийн тамирчидтай хамтарсан бэлтгэл сургуулилт, Сагсан бөмбөг, волейболын төрөлд оролцох багийн тамирчид бэлтгэл сургуулилтаа төв зааланд хийж бусад төрлүүд нь тус бүрдээ бэлтгэл сургуулилтаа ханган ажиллаж байна.

Шинэ Гурвансайхан сумын 5 жилийн ойн ажлын хүрээнд зохион байгуулж буй волейболын тэмцээнд дасгалжуулагч Д.Болор-Эрдэнэ тамирчдын хамт амжилттай оролцсон. СӨБ, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх аргагүй үндэсний сургалтыг аймгийн ЗДТГ, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, ТХДЖТ-т нэгдсэн сургалтууд болж, Эрдмийн далай цогцолбор сургууль, Цэгцбилиг сургуулиудад 2019 оны 8 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд 648 багш хамрагдлаа. Дундговь аймгийн багш нарын 71 дэх удаагийн бага хурал сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, сургалтын менежерүүдийг хамруулан 8 дугаар сарын 23-нд 81 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулалаа. Бага ангийн сурагчдын сурах бичгийг нөхөн хангалт 8732, дунд ангийн сурагчдын 40 хувьд олгох 2728 ширхэг сурах бичиг ирснийг сургуулиудад тараасан байна. Баруун бүсийн дотуур байруудад туршлага судлах, эко дотуур байрын төслийн хаалтын ажиллагааны сургалтад Говь-Алтай аймагт Баянхонгор, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгууд 8 дугаар сарын 25.26-ны өдрүүдэд оролцлоо. Гурвансайхан сумын нутаг Их газрын чулууны уул байгалийн Задгай театрт Мөнх тэнгэртээ өргөх дуун цацал 3000 уртын дууч морин хуурчдын урлагийн наадмыг амжилттай зохион байгууллаа. Аймгийн шигшмэл хурдан хүлэг шалгаруулах “Мандалын шигшмэл хурд 3” хурдан морины уралдааны уралдаанч хүүхдийг цахим бүртгэлд бүртгэж, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллалаа. 2018 оны хүүхэд хамгааллын статистик мэдээ, Бүрдийн уянга хүүхдийн зусланд амарсан амрагч хүүхдүүдийн мэдээллийг Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн нэгдсэн санд орууллаа. Улаанбаатар хотноо “Хүчээ нэгтгэе: залуучуудын манлайлал” үндэсний 5-р чуулганд ЗХТөвийн ажлын албаны нарийн бичиг, сургалт хариуцсан ажилтан, зорилтот бүлгийн болон малчин, хувиараа бизнес эрхлэгч залуусын төлөөлөл оролцлоо.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Шүлхийн дархлаажуулалтын ажил үргэлжлэн явагдаж 12 сумын 2600 өрхийн 46,7 мянган үхэр, 1157,0 мянган бог, бүгд 1203,7 мянган мал вакцинжуулж 92,0 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Сахуугийн бактеринг 15 суманд олгож дархлаажуулалтын ажлыг эхэлж 1 ээлжийн тарилгыг хийж дуусгасан. Үйлчилгээний хөлсний материалыг бүрдүүлж ОНХС-д өгсөн. Мал угаалгын ажил зарим суманд эхэлж 60,0 гаруй мянган мал ванндсан.

Сайнцагаан, Эрдэнэдалай суманд шинээр суурин онгоц ашиглалтад орсон. Хөдөө аж ахуйн зах зээл төслийн хүрээнд Сайхан-овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт суманд 7 угаалгын онгоц /ванн/ барих ажил хийгдэж байна. Мал угаалгын ажил 15 суманд эхэлж 190,961 бог, 297 толгой бод мал угаасан байна. ХХААХҮЯамны сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг

“Өндөршил” адуунд намрын хянан магадлагааг хийж байна. Засгийн газрын 122 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт тэмээ, хонины ноос бэлтгэн нийлүүлсэн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох” журмын дагуу үндэсний боловсруулах үйлдвэрт тэмээ, хонины ноос тушаасан малчдын ноосны материалыг сумдаас хүлээн авч холбогдох хугацаанд ХХААХҮЯаманд хүргэх ажлыг зохион байгуулж байна. Улсын архивын үзлэг, шалгалтыг угтаж аймгийн ЗДТГ-аас томилогдсон ажлын хэсэг урьдчилсан үзлэг, шалгалтыг хийж зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ. Сумын засаг даргын аюулгүй нөөц бүрдүүлэлт болон гар хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-д хүргэсэн. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 15 суманд хуваарилан олгож дархлаажуулалтын ажлыг эхлэн 10,3 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Сумдын баталсан төлөвлөгөөг нэгтгэхэд угаалганд 1366,6 мянга мал хамруулахаас одоогийн байдлаар 428,6 мянган бог, 0,5 мянган бод мал хамруулснаас 329,7 мянган бог малыг ваннанд шумбуулж угаасан байна. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ӨМӨЗО-ны хөх хотод Монгол хятадын хамтарсан Экспо үзэх аялалд оролцох 3 малын эмчийн нэрийн материалыг бүрдүүлж Мал эмнэлгийн газарт явууллаа.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ,

ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Улсын төсвийн хөрөнө оруулалтаар хийгдэх 15 сумын 41 цэгт усны геофизикийн хайгуулын ажлын тендерт “Эрдэнэдриллинг” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэж байна. “Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах журам”, “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-д санал авахаар холбогдох мэргэжлийн байгууллагуудад хүргүүлжээ.

Экологийн боловсролыг сонирхолтой байдлаар сурталчлах үүднээс "Байгаль орчны кино клуб"-ыг 7 хоног бүр англи хэл дээр БОАЖГазарт хичээллүүлэхээр боллоо. Өлзийт сумын 250 суудалтай соёлын төвийн барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэлээ. Монгол Улсын "10 аймгийн төвийн дулааны станц барих" төслийн зөвлөх үйлчилгээний БНСУ-ын "KDHEC" компани, туслан гүйцэтгэгчээр Монгол Улсын "Richwell" компани болон Эрчим хүчний яамны төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерүүдээс бүрдсэн баг 8 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд аймгийн төвд шинээр баригдах дулааны станц, ус дулаан дамжуулах төв, гадна дулааны шугам сүлжээний талбайн судалгааг хийж, төсөлд оролцогч талуудын хариуцах ажлын хүрээ, зааг, барилга байгууламж баригдах газар, талбайн хэмжээг эцэслэн тохиролцох, төслийн зураг төслийг боловсруулахад шаардлагатай өгөгдөл мэдээллийг газар дээр нь нягтлан шалгаж ажиллалаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Хандлагаа өөрчилье” багц ажлын хүрээнд “Ногоон паспорт” аяныг Улаанбаатар хот, 21 аймгийн хэмжээнд зохион байгуулж байгаа бөгөөд Дундговь аймгаас Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 10 дугаар ангийн сурагч Э.Наранзул шилдэг сурагчаар шалгарч, Бээжин хотоор аялах эрхээр шагнууллаа. “Хотод ойрхон говь” аялал жуулчлалын нэгдсэн эвентийг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, ажил үүргийн хуваарилалтыг хийлээ. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын мэдээлэлд үндэслэн байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тодорхойлуулах ажлын үнийн саналын урилгыг байгаль орчны үнэлгээний эрхтэй тусгай зөвшөөрөл бүхий 6 аж ахуйн нэгжид хүргүүлсэн байна. Мандал шилтгээн ХХК-ны барилгын материалын төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргав. Сайнцагаан сумын 150 ортой цэцэрлэг, Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын дуусгалтын ажлуудад барилгын ажил эхлүүлэх, үргэлжлэх зөвшөөрөл олголоо. Сайнцагаан суманд улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй аймгийн Цагдаагийн газрын барилга, Төв халхын дуулалт жүжгийн театр, Мандалговь хотын үерийн далангийн байгууламжийн барилга угсралтын ажлуудад захиалагчийн хяналт гүйцэтгэлээ. “Өндөршил сумын цэцэрлэгийн барилга”-ын ажлын гүйцэтгэгийг сонгон

шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг захиалагчид хүргүүлээ. Гурвансайхан сумын Мирайфлюорид ХХКомпанийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авч аймгийн хэмжээнд хийгдэж буй нөхөн сэргээлтийн мэдээг нэгтгэж БОАЖЯаманд хүргүүлсэн. Эрдэнэдалай сумын Цагаан-Овоо нутагт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Окслей гоулд” ХХК-ны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, усны дүгнэлтийг гаргалаа. Өлзийт сумын Цагаан суваргат зохион байгуулагдах “Их говийн тэмээ” эвент арга хэмжээний байрлалыг сонгож, нутгийн малчидтай уулзалт хийлээ. Баянжаргалан сумын 100 ортой цэцэрлэгийн барилгыг ашиглалтанд оруулах комисс ажиллалаа. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 3000м3/хоног хүчин чадалтай биологийн цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж барих гүйцэтгэгчийг шалгаруулах ажлын тоо хэмжээнд тэргүүнд шаардлагатай 5.57 км ариутгах татуургын шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг нэмж шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээ. Санхүүгийн хяналт, аудитын албаны хэрэгцээний автомашины тендерийг нээж үнэлгээ хийж байна. Аймгийн төвийн авто замын нөхөөсний ажлын тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийг захиалагчид хүргүүлсэн байна.

ДОЛОО. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

АДААЦАГ: Мөнх тэнгэртээ өргөх дуун цацал 3000 морин хуурч, уртын дуучдын их наадамд сумаас оролцох 140 иргэдийн бэлтгэл сургуулалтыг ханган амжилттай оролцсон. Ардын хувьсгалын 98-н жил, Адаацаг сум байгуулагдсаны түүхт 60-н жилийн ойн баяр наадмаар унаач хүүхдийн аюулгүй байдал болоод хамгаалалтанд хяналт тавин ажиллаа. Азарга-84, соёолон-84, шүдлэн-87, Их нас-127, хязаалан-91, даага-65 тус тус 6-н нас уралдаж нийт 156 хүүхэд унаж уралдлаа. Мөн аймгийн ГБХЗХГазар 8-н хүний бүрэлдэхүүнтэй баг ирэн хамтран ажиллаа. Залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малжуулах төсөлд 3 өрхийг 15,0 сая төгрөгийн мал нийлүүлж дууссан байна. Мобайл технологи хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөдөөгийн багийн иргэдэд гэрийн нөхцөлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бэлтгэл хангагдсан. 2019 оны хонь, тэмээний ноосны урамшууллын материалыг малчдаас хүлээн авч бүрдүүлж байна. Сумын малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлын үндсэн судалгааны нэгтгэлийг хийж дууссан. Өвөр-Урт багийн хөшөөтийн булгийн эхийг хаших ажил эхлээд байна. Сумын төвийн хогийн цэгийг Байгаль хамгаалах сангийн 3690,0 сая төгрөгний хөрөнгөөр 1 га газрын хогийг шууж цэгцэлсэн. ОНХСангийн хөрөнгийн ЗДТГ-ын цайны газрын их засвар 8 сая төгрөгөөр, ЗДТГ-ын цайны газрын ширээ сандал 3,0 сая төгрөгөөр, Соёлын төвд урлагийн хувцас, Соёлын төвд шинээр 8 морин хуур 2,0 сая төгрөгөөр зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлэн комисс хүлээн авсан байна. Адаацаг сумын хэмжээнд Мал угаалгын ажил 8-р сарын 5-аас эхлэн эхний ээлжийн угаалгын ажил явагдаж байна. Сүм, Ар-Урт, Өвөр-урт 3 багт ванндаж угааж байна.Хашаат багт аймгийн МЭГ-тай гэрээ байгуулан Дук машинаар шүржиж угаах ажил хийгдээд явж байна.

БАЯНЖАРГАЛАН СУМ: Үнэн-Анд ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд сумын төвийн худгийг smart болгож ард иргэд ухаалаг худгаар үйлчлүүлж эхэллээ. Шилийн гол 1-р баг, Энгэр-Ус 2-р багууд багийн өдөрлөгүүдээ 2019 оны 8 сарын 18,19-ны өдрүүдэд зохион байгуулж багийн иргэдэд цаг үеийн мэдээ мэдээлэл хүргэн иргэдийн идэвхийг сайжруулах зорилгоор уралдаан тэмцээн зохион байгуулж тус арга хэмжээний үеэр БОРЖИГИН-2019, УЯХАН ЗАМБУУ ТИВИЙН НАРАН наадмуудад оролцоход дэмжлэг үзүүлсэн малчид, ААН-үүдэд засаг даргын тамгын газраас ТАЛАРХАЛ гардууллаа. 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын төлөвлөгөө боловсруулж байна. Одоогоор сумын аюулгүйн нөөц 1 тн өвсний нөөцтэй байна. “УЯХАН ЗАМБУУ ТИВИЙН НАРАН” урлагийн их наадмын 3000 уртын дууч, морин хуурчдын наадам буюу “МӨНХ ТЭНГЭРТЭЭ ӨРГӨХ ДУУН ЦАЦАЛ” нэгдсэн тоглолт 2019.08.07-12-ны өдрүүдэд Гурвансайхан сумын нутаг байгалийн үзэсгэлэнт цогцолбор бүхий Их газрын чулуунд амжилттай сайхан зохион байгуулагдлаа. Энэхүү наадамд сум орон нутгаа төлөөлөн 62 уртын дууч, 21 морин хуурч, 29 зохион байгуулагч, аж ахуйн алба бүрдсэн 112 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. Наадмын үйл ажиллагаа олон хүний сэтгэлийг баясгаж, бахархал, бардамналыг төрүүлсэн төдийгүй сумынхаа нэрийг түмний чихнээ дуурсгаж аймаг орноос төрсөн алдартнуудын эгнээд Монгол Улсын Соёлын Тэргүүний ажилтан, Дундговь аймгийн алдарт уртын дуучин Ч.Шинэбаяр, Т.Шону,

Р.Хандсүрэн нар нь манлайлж жагссан бол Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яамны Жуух бичгээр соёлын төвийн эрхлэгч Б.Батчимэг, даага цоллох уралдаанд З.Мөнх-Эрдэнэ дэд байр, сум орон нутгийн зохион байгуулалт, бэлтгэл ажлын хангалт, оролцоо, идэвхи санаачлагаараа бусдыгаа манлайлж соёлын төв нь техник хэрэгсэл, ЗДТГазар батламж медаиолоноор тус тус шагнагдсан амжилттай сайхан оролцлоо. Мөн өвөл цагийн гэрийг Өлзийт, Луус сумдуудтай хамтран тохижуулж, хүрэлцэн ирсэн зочид гийчид, наадамчин олондоо зан үйл, ёс заншлыг харуулсан өв соёл, язгуур урлагийн тоглолтыг харууллаа. БОРЖИГИН-2019 наадамд соёлын биет бус өв уламжлан тээгчид, ардын авьяастан нар оролцож Боржигины өв соёлын хүрээнд урлагийн тоглолт үзүүлж мөн Шагайн харваа, шагайн наадгайн зан үйлийг сурталчлан гуравдугаар байранд орлоо. Мөн хамгийн өндөр настай олон шавь бэлтгэсэн Өвлөн уламжлагчаар Ч.Шинэбаяр шалгарсан.

ГОВЬ-УГТААЛ СУМ: “УЯХАН ЗАМБУУ ТИВИЙН НАРАН УРЛАГИЙН ИХ НААДАМ” “МӨНХ ТЭНГЭРТЭЭ ӨРГӨХ ДУУН ЦАЦАЛ 3000 УРТЫН ДУУЧ, МОРИН ХУУРЧДЫН ТОГЛОЛТ” 2019.08.09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Энэхүү наадамд Говь-Угтаал сумаас 90 уран бүтээлч оролцохоос 94 уран бүтээлч, аж ахуйн алба болон бусад үйл ажиллагааны чиглэлээр 31 хүн нийт 125 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. Монгол Улсын Тэргүүний Ардын Авьяастан цол тэмдэгээр Ш. Мөнхцэцэг, Дундговь аймгийн “Алдарт уртын дуучин” цол, медалиар Ж.Хоролсүрэн нар шагнагдаж “БЭСРЭГ НААДАМ”-ын “БӨХ”-ийн төрөлд аймгийн арслан Т.Занданбат үзүүр, “СУР ХАРВАА”-ны төрөлд спортын мастер Д.Бум-Эрдэнэ түрүү, “ХОС ДААГА”-ны төрөлд морьт багийн малчин аймгийн аварга малчин Д.Түвшинбаярын хос хар даага түрүү, ажирхай багийн малчин Б.Бат-Эрдэнийн хос хүрэн даага гуравт шалгарч “МОРИНЫ ЦОЛ ДУУДАХ” төрөлд Д.Түвшинбаатарын Баяржавхлан түрүүлж Д.Түвшинбаярын Гомбожав гуравт, “УМ МАРЗАЙ” дуудах төрөлд Ж.Төртогтохын Энхмаа түрүү, айрагны баярын “ХУРУУ ГАРГАХ” төрөлд сумын баг түрүүлсэн зэрэг бахдам амжилтыг ГОВЬ УГТААЛЧУУД гаргалаа. Мөн “НЮАНС” хамтлагийн дуучин Д.Дүйнхоржав, цагдаагийн “СҮЛД” чуулгын гоцлол дуучин, Олон Улсын дуурийн дуулаачдын “А” зэрэглэлийн уралдааны тэргүүн байрын шагналт дуучин Ц.Амарболд, “СҮЛД” чуулгын гоцлол дуучин Д.Содномдаржаа нар хүндэтгэлийн тоглолтонд ая дуугаа өргөлөө. Үндэсний бөхийн барилдааны 2-ын даваанд сумын заан Б.Одхүү аймгийн хурц арслан Г.Баяржавхланг өвдөг шороодуулсан уран барилдааныг гаргаж наадамч олныг баясгасан юм.

ӨЛЗИЙТ СУМ: ИТХ-ын ээлжит 9-р хуралдаанаар сумын эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэж Засаг даргад үүрэг өгсөн. Нүүрс тээвэрлэлтийн замын талаар ирүүлсэн малчдын өргөдөл, гомдол, энэ талаар шалгалт хийсэн ажлын хэсгийн тайланг хэлэлцэж авах арга хэмжээг баталлаа. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад өөрчлөлт орууллаа. **ЗДТГ:** Хүн ам, орон сууцны тооллогын баг хариуцсан түр товчоог 18 гишүүний бүрэлдэхүүнтэй сумын Засаг даргын 2019.07.25-ны өдрийн А/119 дүгээр захирамжаар томиллоо. Аймгийн эдийн Засаг нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэл төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Гурвансайхан сумын Их газрын чулуунд 2019.08.10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадам”, “Мөнх тэнгэртээ өргөх дуун цацал” 3000 уртын дууч, морин хуурчдын хүндэтгэлийн тоглолтод 158 уртын дууч, 56 морин хуурчдын бүрэлдэхүүнтэй амжилттай оролцож шилдэг тэргүүний оролцогч сумаар шалгарч Морин хуур хөгжмөөр шагнуулсан. ИТХ-ын дарга Х.Отгонмөнх, Соёлын төвийн эрхлэгч Ц.Хадхүү нар “Талын монгол” телевизд ярилцлага өгч, “Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадам”, “Мөнх тэнгэртээ өргөх дуун цацал” 3000 уртын дууч, морин хуурчдын хүндэтгэлийн тоглолтод оролцогч 158 уртын дууч, 56 морин хуурчид дуулж, хуурдаж сум орноо сурталчилж телевизийн бичлэг хийлгэв. Хүндэтгэлийн тоглолтын баярт мөчид сумын Соёлын төвийн хөгжмийн багш Б.Ууганбаяр Аймгийн “Алдарт морин хуурч”, ахмад ардын авьяастан Б.Зулаа Аймгийн “Алдарт уртын дууч” цол тэмдгээр шагнагдлаа. 2019.08.18-нд тус сум нь анх удаа “Түмэн адууны баяр”, “Их говийн эвент-2019”-ийг тэмдэглэхээр сумын Засаг даргын 2019.07.25-ны өдрийн А/117 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг, Улаанбаатар хот дахь Өлзийт сумын нутгийн зөвлөл, Өлзийт сумын “Тод магнай” морин спорт уяачдын холбоо, Засаг даргын Тамгын газар

хамтран амжилттай зохион байгууллаа. “Түмэн адууны баяр”-ын үеэр Өлзийт сумын “Тод магнай” морин спорт уяачдын холбооны 2019.07.22-ны өдрийн 05 дугаартай хүсэлтээр сумын “Алдарт уяач”-ын болзол хангасан 7 уяачид сумын “Алдарт уяач” цолыг сумын Засаг даргын 2019.07.25-ны өдрийн А/120 дугаар захирамжаар олгож үнэмлэх тэмдгийг гардуулав. “ХОТОД ОЙРХОН ГОВЬ”, “ИХ ГОВИЙН ТЭМЭЭ” эвент нэгдсэн арга хэмжээ 2019 оны 9 дүгээр сарын 7,8-ны өдрүүдэд Өлзийт сумын байгалийн үзэсгэлэнт газар Цагаан суваргат зохион байгуулагдах тул нутгийн малчид, иргэдийг өргөнөөр оролцохыг уриалж сумын цахим хаягт фото аннос мэдээллийг байршуулж иргэд олон нийтэд түгээж байна. 1990-2004 оны 16 хадгаламжийн нэгжийг Аймгийн Архивын тасгаас хүлээн авч Малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах зааварт нэмэлт өөрчлөлт орсны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/09 дугаар тушаалын хавсралтаар малчин даатгуулагчаар тэтгэвэр тогтоолгох холбогдох бичиг баримтаа бүрдүүлсэн 1 малчин даатгуулагчид архивын лавлагаа олгож үйлчилсэн байна. Сумын нутаг дэвсгэрт геологийн судалгааны ажил гүйцэтгэх “Жи Си Пи” ХХК нь Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамны сайдтай байгуулсан ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг танилцуулав. 4-р багийн нутаг “Шарангад” хэмээх газарт иргэд гараар жонш ухаж байна гэсэн гомдлын дагуу хяналт хийж ажиллалаа. Тус газарт очиход хүн байхгүй эвдэрсэн газар ихтэй байсан бөгөөд 8 дугаар сарын 7-11-ны өдрүүдэд “3000 уртын дуучин, морин хуурчдын” наадам зохион байгуулагдсан өдрүүдэд иргэд гараар болон техник ашиглан газар ухаж жонш олборлосон тухай мэдээллүүдийг олж аваад байна. Үүнтэй холбогдуулан аймгийн цагдаагийн газар, болон МХГазарт мэдээлсэн. Сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй “Страто” ХХК-ний нүүрс тээвэрлэлтийн замын ажил болон зам дагуух айл, өрхүүд, зам түшиглэн үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн нөхцөл байдалтай танилцсан ажлын тайланг ИТХ-ын 9-р хуралдаанаар хурлын төлөөлөгч нарт танилцуулж цаашид авах арга хэмжээг хэлэлцэв.

САЙХАН-ОВОО СУМ: Өнгөрсөн 8-10-ны өдрүүдэд сумын нийт нутгаар бороо хур тундас нэлээд хэмжээгээр орсноос цаашид бэлчээрийн даац нэмэгдэх, малын тарга тэвээргэ авах боломжтой боллоо. Мөн малчид өвөлжилтийн бэлтгэл хангах хашаа хорооны засвар хийх, бууц хөрзөнгөө сийрүүлэн зөөх, ариутгал үйлчилгээнд хамрагдаж байна. Энэ жил тус суманд Адуу 8000, Үхэр 3000, Тэмээ 1100, Хонь 89000, Ямаа 100000 Нийт 201100 мал өвөлжих урьдчилсан тооцоотой байна. Ирэх 9 дүгээр сарын 8-9 өдрүүдэд Сайхан-Овоо суманд “Нүүдэлчдын баяр” уламжлалт мал аж ахуйн зан заншлын баярыг аймгийн хэмжээний арга хэмжээ болгон хамтран тэмдэглэхээр шийдвэрлэсэн байна. Мөнх тэнгэртээ өргөх дуун цацал “Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадамд 8 дугаар сарын 7-12 ны өдрүүдийг хүртэл Их газрын чулууны Задгай театрт зохион байгуулагдаж сумаас уртын дууч 55, морин хуурч 25 нийт 80 ардын авьяастаны бүрэлдэхүүнтэй амжилттай оролцож ирсэн. Мөн “Монгол хүрээ” ёс заншилын 4-н улиралын Зуны гэр тохижуулж ёс заншилыг харуулсан үйл ажиллагааг сайн зохион байгуулж 12 үзмэрийн зүйлс бэлтгэн оролцлоо.

